



МОНГОЛ УПСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: under@ndaatgal.mn, <http://www.ndaatgal.mn>

2024.12.18 № 01/2627

талай _____ -ийн № _____ -т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
“Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны
төлөвлөгөө”-ний биелэлтийг хүргүүлж байна.

Тайланг нотломжийн хамт Авлигатай тэмцэх
газрын hutulbur.iaac.mn сайтад байршуулсан болно.

Хүлээн авна уу.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ГАНЦЭЦЭГ





“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шорк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, гарын авлагыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын салбарын даатгалын салбарын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж байх;	- Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх, (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шорк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын салбарын албан хаагчид болон олон нийтэд сурталчилж арга хэмжээний хүрээнд албан үүргээ гүйцэтгэсний төлөө нэмэлт төлбөр, шууд болон шууд бусаар бэлэг, хандив, бусад санхүүгийн туслалцаа авах нь авлигын зөрчил болох дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд: • Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Авлигын эсрэг хуулиас”, “Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглоно”, “Авлигын хэлбэрүүд”, “Авлигын эсрэг таны оролцоо” “Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт”, Бэлэг үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд” гэсэн 6 төрлийн постер, Нийгмийн даатгалын ерөнхий газраас бэлтгэсэн гаргасан 2 төрлийн постерийг тодорхой хугацааны давтамжтай байгууллагын вэб сайтад байршуулан олон нийтэд түгээв; • “Хамтдаа тэвчье, сэргийлье” уриатай АХА тэмцээнийг 3 аймаг, 2 дүүргийн Нийгмийн даатгалын газар зохион байгуулан нийт 215 албан

	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	хаагч хамрагдаж Авлигын эсрэг хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актын талаарх мэдлэгээ сайжруулав. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг "Нээлттэй мэдээллийн сар" болгон зарласантай холбоотой 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр ажил олгогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, зөвлөн туслах, хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор "Нээлттэй хаалганы өдөрлөг", "Явуулын үйлчилгээ"-г зохион байгуулав. Нээлттэй хаалганы өдөрлөгийг 21 аймгийн төв, 176 сум, 9 дүүргийн нийт 341 байршилд зохион байгуулж, 2514 малчны хот, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байранд хүрч ажиллаж, нийт 16,674 иргэнд зөвлөгөө өгөв. Үүнд: • Тэтгэврийн асуудлаар- 5814 иргэн; • Тэтгэмжийн асуудлаар- 3115 иргэн; • Шинээр ажил олгогч бүртгүүлэх талаар- 70 иргэн; • Сайн дурын даатгалын талаар- 4168 иргэн; • Эрүүл мэндийн магадлалын талаар- 41 иргэн; • Аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл төлөлтийн талаар - 1162 иргэн; • Нэрийн данс, нөхөн даатгалын талаар- 27 иргэн; • Ажилгүйдлийн тэтгэмжийн талаар- 134 иргэн; • Цахим үйлчилгээний талаар- 2,143 иргэн. Мөн Нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийгмийн даатгалын үйлчилгээг 5,340 иргэнд үзүүлсэн. Үүнд: • Сайн дурын даатгалын гэрээ шинээр байгуулсан- 1018 иргэн; • Гэрээгээ сунгасан- 1083 иргэн; • Цахим үйлчилгээ авсан /AR /- 2437 иргэн; • Аппликэйшн суулгасан- 540 иргэн;
--	--	--	--

			• portal.ndaatgal нэвтэрч үйлчилгээ үзүүлсэн- 158 иргэн; • Лавлагаа авсан- 25 иргэн; • Материал бүрдүүлж өгсөн- 79 иргэн. Тус арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн 5 төрлийн 35,436 сурталчилгааны гарын авлага тарааж, хэвлэл мэдээллийн 148 байгууллагаар өдөрлөгийн үйл ажиллагаа, нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчлав.
1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарын шинэчилж, тогтмол ажиллуулах;	-Мэдээллийг шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	сар бүр бүр	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах, авлигыг хянах дотоод хяналтын механизм бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй байх арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: • Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээллийн самбарт Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнийг мэдээлэх талаар уриа, Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх "110 дугаар"-ыг тус тус байршуулан иргэд, даатгуулагчид, албан хаагчдад түгээв; • Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагын зүгээс ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ илэрхийлэн иргэд, даатгуулагчид, албан хаагчдад зориулсан 2 төрлийн постерийг бэлтгэн Нийгмийн даатгалын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулав.
			Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт 2024 оны "Төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллах тухай"

01/2294 дугаар албан бичгээр ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй байх тухай 2 төрлийн постерийн эх бэлтгэлийг хүргүүлэн, нийт албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй байхаа илэрхийлэх уриалга гаргав.		Нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд 2024 онд Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаар дараах сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд: - Авлигатай тэмцэх газартай хамтран аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ангид байх, хэрэв зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх тухай цахим сургалт зохион байгуулж аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын 31 салбар зөвлөлийн 249 гишүүнийг хамруулав; - Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Шагдар, Л.Содбаяр, хяналтын прокурор А.Азжаргал нар "Авлигын гэмт хэрэг болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал" сэдвээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад сургалт зохион байгуулж, сургалтад 50 албан хаагч хамрагдав; - Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудад цахимаар зохион байгуулсан "ХАСХОМ мэдүүлэх нь" сургалтад салбарын 250 албан хаагч хамрагдав; "Авлигын шалтгаан хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Авлигын гэмт хэрэг түүний ойлголт" сэдвээр Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдад 2024.10.18-ны
1.4.Төрийн албанд томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх.	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх. -Тайланд нотломжийн хамруулсан байх.	

			өдөр сургалт зохион байгуулж сурталтад нийт 236 албан хаагч хамрагдав; Улсын Их Хурлын байнгын хорооны 2024 оны "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас эрх бүхий албан тушаалтан нарт зориулан зохион байгуулсан 2 өдрийн цахим сургалтад 30 албан хаагчийг хамруулав. Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн журам, дүрмийн төсөлд санал тусгасан байх арга хэмжээний хүрээнд дараах журмын төсөлд санал хүргүүлэв. Үүнд: • Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оын 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Санал авах тухай" 05/18449 дугаар албан бичгээр ирүүлсэн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийн маягт нөхөх заавар"; • Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтад "аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байцаагч, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг "ТЗ-8", "ТЗ-9" зэрэглэлээр баталсан. Байцаагч, мэргэжилтнүүд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгож, баталгаажуулж, түдгэлзүүлж, цуцална", мөн зүйлийн 38.6 дахь хэсэгт "Нийгмийн даатгалын улсын байцаагч нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, ёс зүйн зөрчил гаргаагүй, мэргэшсэн, нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн зэрэг шалгуурыг хангасан байна" гэж тус тус заасны дагуу "Нийгмийн даатгалын улсын байцаагч"-ийн эрх авснаар Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу "ТЗ-7" зэрэглэлийн цалинг авах эрхтэй болдог.
1.5. Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн журам, дүрмийн төсөлд санал тусгасан байх.	Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн журам, дүрмийн төсөлд санал өгч ажилласан байна.		

				Харин албан тушаалын тодорхойлолт нь ТЗ-8, ТЗ-9-өөр батлагдсан тул хувийн ашиг, сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг хүлээдэггүй тул Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан "Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсааг"-ын 1.3 дахь хэсэгт заасан "ТЗ-1"-ТЗ-7"-д хамаарах албан тушаалтан; гэснийг "ТЗ-1"-ТЗ-9"-д хамаарах албан тушаалтан; гэж өөрчлөх санал хүргүүлэв.
ИЛ ТОД БАЙДЛЫГ СУЖРУУЛАХ ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛ БУУРУУЛАХ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД				
2.1. Нийгмийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчилөөс ангид байх талаар зохицуулалт тусгах.	Гэрээ, авлигаас ангид байх, мэдээлэх, үүргийг тусгасан байх.	хэлэлцээрт	Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж байгаа аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнтэй Хамтран ажиллах, Худалдах худалдан авах, Хөлсөөр ажиллах, Түрээсийн, Хөдөлмөрийн гэрээг тус тус байгуулан ажиллаж байна. Дээрх гэрээнүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусган "авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх", "уг заалтыг зөрчсөн тохиолдолд талууд хариуцлага хүлээх", "эрх бүхий байгууллагад мэдэгдэх" заалтуудыг тусгаж арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж байна.	2024 онд Нийгмийн даатгалын байгууллага нийт 80 гэрээнд "Талууд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх" гэсэн заалтыг тусган байгуулсан бөгөөд тайлант хугацаанд уг заалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гараагүй болно.
2.2. Нийгмийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, даатгуулагчид болон албан	Даатгуулагчид болон албан хаагчаас түүвэрийн аргаар судалгааг авч		Албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулан санал асуулгын дүнг үндэслэн дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:	

2

хаагчдаас авлигад өртөх эрсдлийн судалгаа авах.	тайлан гаргаж эрсдэл үнэлсэн байна.	• 2024 оны эхний хагас жилд Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд бусад байгууллага, иргэдэд Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлах, таниулах ажлын явцад салбар дахь авлигын нөхцөл байдлын талаарх асуулгыг 200 хүнээс авч боловсруулалт хийж ажиллав. Уг судалгаагаар Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахын тулд авлига өгсөн, авсан, шаардсан зөрчил гаргаж байгаагүй гэсэн дүгнэлт гаргасан. • 2024 оны сүүлийн хагас жилд Судалгаа, актуар тооцооллын хэлтсээс нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчид болон нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авсан иргэд, даатгуулагчдаас авлига, ашиг сонирхлын талаар судалгаа авах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 03-18-ны өдрүүдэд зохион байгуулав. Судалгаанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, 21 аймаг, 9 дүүргийн 707 албан хаагч оролцож түүнээс шийдвэр гаргалтын түвшинд эрх бүхий албан хаагч ангид байж чаддаг гэж 82.4 хувь нь, тушаал дэвших, шагнал урамшуулал олгох үйл ажиллагаа шударга явагддаг гэж 86.7 хувь нь тус тус үнэлсэн дүнтэй байна. • Иргэд, даатгуулагчдын судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн 512 хүн хамрагдсан. Үүнээс үйлчилгээ авагчдын 94 хувь нь үйлчилгээ, мэдээлэл бүрэн, хялбар шуурхай авч чадсан ба 93 хувь нь зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн ажилтны харилцаа, хандлагыг сайн гэж дүгнэв. /Хавсралтаар судалгааны тайланг хүргүүлэв/
2.3. Даатгуулагчид болон албан хаагчаас авсан судалгааны тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл хүргүүлэх арга хэмжээ зохион байгуулах.	Даатгуулагчид болон албан хаагчаас авсан судалгааны тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл	2024 оны 9, 10 дугаар сарын хугацаанд Засгийн газрын 11-11 төвд иргэдээс ирүүлсэн Нийгмийн даатгалын байгууллагатай холбоотой хүнд суртал, чирэгдэл үүсгэсэн тухай гомдол, мэдээлэл, судалгааг Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газраас авч иргэд, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний хүнд суртал, чирэгдэл үүсгэж

	хүргүүлэж арга хэмжээ зохион байгуулсан байна. байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлсон. Хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа шалтгаан нөхцөлтэй холбоотой нийт 9 өргөдөл гомдол ирсэн. Үүнд: 1. Ажилгүйдлийн тэтгэмжийг цаг хугацаанд нь авч чадахгүй байгаа талаар -2 2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгогдохгүй байгаа талаар -1 3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн нөхөн тайлан өгөх гэсэн боловч системийн шинэчлэлтэй холбоотойгоор шийдэгдэхгүй байгаа талаар -5 4. Нийгмийн даатгалын байгууллага цайны цагаар үйлчилгээ үзүүлэхгүй байгаа талаар-1 Ирүүлсэн өргөдөл, гомдолд дурдагдсан асуудлуудыг судлан нэгтгэн шийдвэрлэхийн тулд дараах ажлыг зохион байгуулав. Үүнд: • Ажилгүйдлийн тэтгэмж цаг хугацаандаа олгогдохгүй байгаа гомдлыг шалгаж үзэхэд тэтгэмж олгох хугацаа болоогүй байсан 1 иргэнд холбогдох хууль, журмыг тайлбарлан зөвлөгөө өгөв. 1 иргэний тэтгэмжийг нь гомдол гаргасны дараа олгосон байсан тул холбогдох мэдээллийг өгсөн; • Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгогдохгүй байгаа талаар гомдол гаргасан иргэний тэтгэмж олгох хугацаа болоогүй хянагдаж байсан тул хууль, журам тайлбарлан хариу өгсөн; • Нийгмийн даатгалын нөхөн тайлан өгөхтэй холбоотой гарсан 4 удаагийн гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэв. Дээрх асуудлыг дахин давтан гаргуулахгүй байх арга хэмжээг авав. Нийгмийн даатгалын байгууллага цайны цагаар үйлчилгээ үзүүлэхгүй байгаа талаар гаргасан гомдолд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цайны завсарлагааны цагтай ажиллаж байгаа талаар хариуг өгч тус тус шийдвэрлэсэн.
--	---

2.4. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багсгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах	Нийгмийн даатгалын цахим системд хөгжүүлэлт хийгдсэн, шинээр цахим үйлчилгээ нэвтрүүлсэн байх.	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багсгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: 1. Мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэн нэвтрүүлэв. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан, уян хатан, динамик суурьтай, бодит цагийн горимд ажиллах мэдээллийн нэгдсэн систем "SICOS", мөн иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан "Иргэний болон ажил олгогчийн портал систем /Portal.ndaatgal.mn/"-ийг 2024 оноос эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж байна. Ингэснээр 2024 оны 11 дүгээр сарын байдлаар "SICOS" системээр 279.4 мянга, Portal.ndaatgal.mn системээр 191.2 мянга, нийт 470.6 мянган тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгал, ажил олгогчийн хүсэлтийг хүлээн авч 95.5%-ийг шийдвэрлэв. Үүнээс: • Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх 149.0 мянган хүсэлт; • Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж авах хүсэлт, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох 231.0 мянган хүсэлт; • Өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэвэрээ өөрчлөн тогтоолгох 89.0 мянган иргэний хүсэлт. Давхардсан тоогоор 6.5 сая тэтгэвэр авагчийн тооцооллыг цахим системээр тооцоолон холбогдох банкууд руу илгээсэн. 59.5 мянган ажил олгогчийн сар бүр илгээсэн 566.7 мянган удаагийн, давхардсан тоогоор 8.6 сая албан журмын
--	---	---

	даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 100% цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн. Ажил олгогчоос цахимаар илгээсэн 127.5 мянган албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлэв.
	2. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар хүргэв. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлж бодит цагийн горимоор онлайн мэдээллийн сан бүрдүүлсэнтэй холбогдуулан иргэд, даатгуулагчид, ажил олгогчдын мэдээллийг агуулсан, 60 орчим төрлийн сервисийг шинэчлэн боловсруулж Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд байршуулан хэвийн ажиллагааг ханган ажиллалав. Ингэснээр ХУР системд байршуулсан нийт 80 гаруй төрлийн сервисээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллага, банк санхүүгийн байгууллага, Элчин сайдын яам, консулын газрууд нийгмийн даатгалтай холбоотой мэдээллээ бодит цагийн горимоор авч байна. Тухайлбал: • 2024 оны эхний 11 сарын байдлаар ХУР системд нийгмийн даатгалын үйлчилгээг авахаар нийт 39.0 сая орчим удаагийн хандалт хийгдсэн байна. • Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн ЕМонголиа порталаар 14.8 сая удаагийн хандалт хийгдэж нийгмийн даатгалын 12 төрлийн үйлчилгээг цахимаар авсан байна. • Иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан портал системээр 135.2 мянган даатгуулагч, ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан байна.

			1150 эрүүл мэндийн байгууллагаас 183.3 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 61.7 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 245 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна. Портал систем болон "Нийгмийн даатгал" аппликейшнээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид зориулсан портал систем болон ухаалаг төхөөрөмжид суурилсан Нийгмийн даатгал аппликейшнийг ашиглан нийт 969.4 мянган албан журмаар даатгуулагч, 166.9 мянган сайн дураар даатгуулагч шимтгэл төлөлтийн мэдээллээ авах, харах, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, төлбөр төлөх, мөн тэтгэврийн мөнгөн хуримтлалын тооцооллоо харах боломжийг бүрдүүлж нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахимаар хүргэв. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1-р улирлын байдлаарх нийгмийн даатгалын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган www.opendata.gov.mn болон www.ndaatgal.mn вэб сайтуудад хугацаанд нь байршуулав.
3	3.1.Тухайн жилд даатгалын байгууллагаас ашиг сонирхлын зөрчил үүсэн эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн тохиолдолд тухайн	Нийгмийн даатгалын байгууллагаас авлига ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага	Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн тохиолдол байхгүй байна.
	АВЛИГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСЭХ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД		

зөрчил гаргасан нэгжид тухайлан арга хэмжээ авах, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах.	хүргүүлсэн тохиолдолд тухайн зөрчил гаргасан нэгжид тухайлан арга хэмжээ авах, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилган эрх бүхий байгууллагад тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас Завхан аймгийн Нийгмийн даатгалын газарт төлөвлөгөөт бус шалгалт явуулж шалгалтын дүнд илэрсэн зөрчлийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэхийг шалгуулахаар тус газрын 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/1545 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүсэлт - хүргүүлж Нийгмийн даатгалын салбарын дотоод шударга байдлыг сайжруулан ажиллав.
3.2.Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөг батлан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөг батлах, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/48 дугаар тушаалаар "Шударга байдлын үнэлгээг сайжруулах 2024 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан салбарын хэмжээнд хэрэгжилтийг зохион байгуулав. Уг төлөвлөгөөг "Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах" чиглэлээр 8 арга хэмжээ, "Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах" чиглэлээр 2 арга хэмжээ, "Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах" чиглэлээр 1 арга хэмжээг тусган төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж Авлигатай тэмцэх газарт хагас, бүтэн жилээр тус тус биелэлтийг хүргүүлэв. /Нотломж хавсаргав/
3.3.НДЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд мониторинг хийх, зөвлөмж гаргах.	НДЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд мониторинг хийж зөвлөмж гаргасан байна.	Дотоод аудит, мониторингийн газраас Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны ажлын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэх 3 зорилтын 12 арга хэмжээг тусгагдсан байна. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг харуулбал: - "Үр дүнтэй" зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан буюу 100 хувийн биелэлттэй 9 арга хэмжээ; - "Тодорхой үр дүнд хүрсэн" зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн

		гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 70-99 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ. Нийгмийн даатгалын ерөнхий газар төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг зохих түвшинд биелүүлсэн тул төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 94.8 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлсэн. Дотоод аудит, мониторингийн газраас Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг үндэслэн үйл ажиллагаандаа анхаарах асуудал, зөвлөмжийг гаргав.
--	--	--